2

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 41 44 Факс: (976-51) 26 41 24
Цахим хуудас: www.frc.mn

2024 11 28 № 1/3900

танай ____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Г.ОЧИРБАТ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар асуулга тавих тухай албан бичигтэй танилцлаа.

Монгол улсад санхүүгийн салбарын 90 хувийг банкны салбар дангаар шахуу бүрдүүлж системийн эрсдэлийг нэгэнт бий болгоод байсан. Иймд санхүүгийн салбарын гурван тулгуур болох банкны буюу мөнгөний зах зээл, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн санхүүгийн системд эзлэх хувийг зохистой түвшинд хүргэн тэнцвэржүүлэх, зээлийн хүүг бууруулахад эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байсан.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд батлсан "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо дангаараа болон Засгийн газар, Монголбанктай хамтран нийт 4 чиглэлийн хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба энэхүү стратегид анх удаагаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх замаар санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах цогц арга хэмжээнүүд тусгагдсанаараа ихээхэн онцлогтой юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хэрэгжилт, үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 2020 оноос хойш улирал бүр биелэлтийг тооцож, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж байсан бөгөөд Таны асуулгын хариуг хүргүүлж байна.

4.1.1.Үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжих чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд:

1.2024 онд Улсын Их Хурлаас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн харилцан уялдаа олон улсын жишигт нийцэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацаат санхүүжилт татах үйл явц хялбаршиж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдүүлэх чиглэлийн боломж бүрдсэн.

1518033780

Тухайлбал, хувьцааны хамтын санхүүжилт, хадгаламжийн сертификат, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зохицуулалт бий болсон. Хууль батлагдсантай холбогдуулан нэр бүхий 10 журмын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн шаардлагын дагуу СЗХ-ны цахим хуудаст байршуулан олон нийтээс санал авч байна.

2.Энэхүү арга хэмжээний хүрээнд үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлсэн, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулах, зах зээлд оролцогчдын хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжлагыг багасгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авснаар анхдагч, хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоо, клирингийн арилжааны төлбөрийн шимтгэлийг бууруулсан. Үүнд:

- "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК нь анхдагч зах зээл дэх арилжааны шимтгэл 0.24 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.12 хувь, "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийг хэлцэл тус бүрээс 0.12 хувь болгон 50 хувиар бууруулсан.

- "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн "Мөнгөн хөрөнгийн журам", "Үнэт цаасны хадгаламжийн журам"-д Засгийн газрын гаргасан өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаанаас худалдагч талаас авдаг байсан 0.00175 хувийн шимтгэлийг авахгүй болж байгаагаас гадна, Засгийн газрын өрийн хэрэгсэлд ногдох хадгаламжийн үйлчилгээний хөлс бондын нэрлэсэн үнээс хамаарч нэгж бондоос 2-50 хүртэл төгрөгийн хөлс авдаг байсан нь 20 хувиар буурч үнийн дүнгийн 0.016 хувь байхаар тогтоосон.

- "Үнэт цаасны клирингийн журам"-ын хүрээнд Засгийн газар, аймаг, нийслэлийн өрийн хэрэгсэл гаргахад тооцогдох клирингийн үйлчилгээний шимтгэлийг бусад өрийн хэрэгсэл гаргагчийн шимтгэлээс 2 дахин багаар тогтоосон. Тухайлбал, Засгийн газрын үнэт цаас, Аймаг нийслэлийн үнэт цаасанд ногдох үйлчилгээний шимтгэл 0.00375 хувь байгаа бол бусад өрийн хэрэгсэлд ногдох үйлчилгээний шимтгэл 0.0075 хувь байгаа юм.

- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь байсныг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоож, 50-75 хувиар бууруулан 0.25-0.5 хувь болгосон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.05 хувь болгосон.

- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Бүртгэлийн журам"-д хувьцааг бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 20-40 хувиар бууруулан 0.06-0.08 хувь болгосон. Мөн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 0-36 хувиар бууруулан 0.064-0.1 хувь болгосон.

- "Арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтөөр "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар хийгдэх хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн шимтгэлийг арилжааны үнийн дүнгээс үл хамааран 0.3 хувиар тооцох, арилжааны шимтгэлийн хувь хэмжээг 25 хувиар бууруулан тогтоосон.

• "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын нэмэлт өөрчлөлтөөр хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.25 хувь, жилийн үйлчилгээний хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.025 хувь болгон тус тус бууруулан тогтоосон.

• Санхүүгийн зохицуулах хороо уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн спот болон форвард гэрээний арилжаанаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийн дээд хязгаарыг худалдан авагч талаас 0.5 хувиас ихгүй, худалдагч талаас 1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй байхаар тогтоосон.

3.Үнэт цаасны зах зээлийг татварын орчноор дэмжих чиглэлээр хуулийн төсөл боловсруулан хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаар:

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг дэмжих хүрээнд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн. Үүнд:

• Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбоотой зардлыг 20 хувиар нэмэгдүүлж тооцон албан татвар ногдох орлогоос хасаж тооцохоор;

• Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагдах ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй компанийн хувьцааны ногдол ашгийн суутган татварыг 10 хувь байсныг 5 хувь болгон бууруулах;

• Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр;

• Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл (бонд), хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар;

• Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл (бонд), хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар;.

• Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьцаа, үнэт цаас борлуулсан орлогод татвар ногдуулахдаа тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцохоор.

4.1.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж,биржийн бус зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

• 2021 онд Биржийн бус зах зээлийн зохицуулалтыг бий болгосноор хөрөнгийн зах зээл хос дугуйтай болж, үүний үр дүнд Монгол Улсад анх удаа дотоодын аж ахуйн нэгжээс

арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлийн өндөр шалгуурыг хангахгүйгээр биржийн бус зах зээлд түргэвчилсэн, шуурхай байдлаар компанийн өрийн хэрэгслийг гаргаж, урт хугацааны санхүүжилт татах зохицуулалтын орчин бүрдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасаа санал болгон, богино хугацаанд санхүүжилт татах боломж нээгдсэн.

Биржийн бус зах зээлийн анхны арилжаа хийгдэж эхэлсэн өдрөөс хойш 2024 оны 3 дугаар улирлыг дуусталх хугацаанд 127 үнэт цаас гаргагчийн төгрөг болон доллароор нийт 3.7 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 234 бонд амжилттай гарч нийт 2.9 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.

• "Үнэт цаасны бүртгэлийн журам"-аар компанийн хувьцаа болон өрийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргахтай холбоотой харилцааг хамтад нь зохицуулж байсан нь зохицуулалтын давхардлыг үүсгэж байсан. Иймд "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ыг тус тус баталснаар арилжаа эрхлэх байгууллага болон төрийн зохицуулагч байгууллагын хоорондох бүртгэлийн давхардал арилж, нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны үр ашиг нэмэгдэх, андеррайтер, үнэт цаас гаргагчийн чиг үүрэг, хариуцлага, мэдээллийн ил тод байдал сайжрах, хувьцаа болон өрийн хэрэгслийн зохицуулалтын давхардал арилж, товч тодорхой болох боломж бүрдсэнээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, түүний тогтвортой байдал, үр ашиг, ил тод байдлыг хангахад чиглэсэн бодлогын томоохон арга хэмжээ болсон.

• "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам"-ыг шинэчлэн баталж, дотоодын болон гадаадын биржид давхар бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшигч бирж хооронд хувьцаагаа хөрвүүлэх эрх зүйн орчин бүрдүүлсэн.

Дээрх арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн өртгийг бууруулах, хөрөнгө оруулагчдад хадгаламжаас өндөр өгөөж хүртэх боломжийг нээж өгснөөрөө санхүүгийн системд банктай өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болох суурь нөхцөлийг бүрдүүлсэн.

4.3.1.Баялгийн сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд:

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор холбогдох яамтай хамтран Үндэсний баялгийн сангийн талаар олон улсын туршлагын талаар судалгаа хийж, хуулийн төслийг боловсруулсан ба 2024 онд Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан.

4.4.1.Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар системд нөлөө бүхий банкнууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаа гаргах замаар 2023 оны 06

дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах үүргийг тус тус хүлээсэн. Энэхүү хууль нь банкны салбарын реформыг эхлүүлж, арилжааны банкнуудад зохистой засаглалыг бий болгох, олон нийтийн хяналттай, нээлттэй, ил тод банкны салбарыг бүрдүүлэхэд томоохон түлхэц болсон. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох хуулийн шаардлагыг хангуулах хүрээнд зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ банкны системд нөлөө бүхий банкнуудын нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, зохицуулалтын бодлогоор тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллалаа.
Үүний үр дүнд "Богд банк" ХК болон системд нөлөө бүхий 5 банк болох "Төрийн банк" ХК, "Голомт банк" ХК, "ХААН банк" ХК, "Худалдаа Хөгжлийн банк" ХК, "Хас банк" ХК-ийн IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжсэн. Нийт давтагдсан тоогоор 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478.54 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна зах зээлийн үнэлгээг 5.86 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Энэхүү стратегийн чиглэлийн хүрээнд мөн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1."Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах" 1.4 дэх арга хэмжээний хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний үнийг шударгаар тогтоох, борлуулалтыг нээлттэй, зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар хийх зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын арилжааг ил тод, нээлттэй болгох зорилгоор Улсын Их Хурлаас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг батлсан. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хуульд заасны дагуу Хорооноос Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаатай холбоотой нэр бүхий 4 журмыг батлснаас гадна "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн нэр бүхий 8 журмыг мөрдүүлж байна. Өнөөдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 12 хуулийн этгээдэд олгосон. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 781 удаагийн арилжаагаар 35.5 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 14.7 их наяд төгрөгөөр арилжаалсан.

2.Стратегийн 1.5 дэх арга хэмжээг хангах хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журмын төслийг боловсруулж олон нийтээс санал авч байна. Мөн гадаад валют, уул уурхайн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн зэрэг хөрөнгөд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг гаргах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Хорооны 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор "Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам"-ыг баталж захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн.

3.Стратегийн 2.4 дэх арга хэмжээний хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй буюу нээлттэй ХК-ийн нийт гаргасан хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж буй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хамгаалах зохицуулалтыг нэмж тусгасан.

4.Стратегийн 1.7 дахь арга хэмжээний хүрээнд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулсан. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар банкны харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосон бөгөөд зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанктай хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.

5.Мөн стратегийн 2.4.3, 2.4.4 дэх арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг батлуулж, Мөнгөн зээлийн бодлогын зөвлөлөөс мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуульд заасан нэр бүхий 5 журмыг баталж, аймаг, нийсэл болон Хороо нийт 401 этгээд буюу 127 иргэн 274 хуулийн этгээдийг бүртгээд байна.

6.Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх 3.1 дэх арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос Сэндбоксын зохицуулалтын орчныг бий болгож нийт 8 бүтээгдэхүүн үйлчилгээг туршин сэндбоксын орчноос гарах, зах зээлд нэвтрэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хавсралт 28 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
1/3900 тоот албан бичгийн хавсралт

УИХ-ЫН 2020 ОНЫ 21 ДҮГЭЭР ТОГТООЛООР БАТАЛСАН
"ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ"-ИЙН 2020-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Д/д	Чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Дэд арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилт
1	Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх	1.4.Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах	1.4.1.Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг дараах байдлаар бүрдүүлэх: - Уг салбарт банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах; - Зээлээр баталгаажсан үнэт цаастай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэх талаар холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх;	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021	Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ")-ны 2020 оны 882 дугаар тогтоолоор хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан Монголын актив удирдлагын корпораци" ХХК оноосон нэрээ "МҮЦСК" ХХК гэж өөрчилсөн. Тус компанид СЗХ-ны 2020 оны 937 дугаар тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. СЗХ-ны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.1-т заасны дагуу СЗХ-ны 2021 оны 329, 580 дугаар тогтоол, 2022 оны 357, 451 дүгээр тогтоолоор "ҮЦСК актив нэг ТЗК" ХХК, "ҮЦСК актив хоёр ТЗК" ХХК, "ҮЦСК актив гурав ТЗК" ХХК, "ҮЦСК актив дөрөв ТЗК" ХХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан нийт 5,379,896 ширхэг үнэт цаасыг бүртгэсэн.` Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд СЗХ-ны дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2023 оны 318/А/231 дугаар тушаал, СЗХ -ны 2023 оны 186, 187, 189 дүгээр тогтоолоор "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам",

	- Мөнгөний бодлогын хороогоор мөнгөний бодлогын хэрэгслээр олгох санхүүжилтийн хэмжээ, нөхцөлийг инфляц, ханш болон гадаад валютын нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан тухай бүрнь хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр баталгаажсан үнэт цаасыг барьцаалсан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй олгож эх үүсвэр бүрдүүлэх.		"Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам", "Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам"-ыг тус тус баталсан. 2024.11.15-ны өдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 11 хуулийн этгээдэд олгосон ба нийт 781 удаагийн арилжаагаар 35.5 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 14.7 их наяд төгрөгөөр арилжаалсан.
1.5.Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	1.5.1.Хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021	1/ УИХ-ын 2024.05.16-ны өдрийн хуралдаанаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг эцэслэн баталсан. Тус хуулийн 19[1] дүгээр зүйлд Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргасан хадгаламжийн сертификат арилжих зохицуулалтыг шинээр нэмж тусгасан. Хуулийн нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан СЗХ-ны даргын 2024 оны 320 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам"-ын төслийг боловсруулан 2024.09.09-ний өдөр олон нийтээс санал

			авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулсан. Мөн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024.09.27-ны өдөр зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудын тусгасан бөгөөд тус журмыг СЗХ-ны хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна. 2/ СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2024 оны А/226/528 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь арилжааны банкнаас гаргасан хадгаламжийн сертификатыг худалдан авч болох зохицуулалтыг нэмж тусгасан. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөл авсан 43 ББСБ нийт 248.7 сая төгрөгийн хадгаламжийн сертификатад хөрөнгө оруулсан байна.
1.5.2.Өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн бүтээгдэхүүн бий болгох	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар, Монголын банкны холбоо	2020-2024	Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-тай хамтран Монгол Улсад Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэх “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2020.05.15-ны өдөр үзэглэлээ. Тус санамж бичгийн хүрээнд факторингийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалт, нийцэл, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд шаардагдах хүчин зүйлсийн судалгааг хийж "Авлага худалдан авалт буюу Факторингийн үйл ажиллагаа эрхлэх гарын авлага" боловсруулсан ба тус гарын авлагыг 531 ББСБ-д хүргүүлсэн. Түүнчлэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд факторингийн компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгасан. АХБ-наас хэрэгжүүлж буй TA 9654-MON: Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний

				зохицуулалтын орчны суурь судалгааг хийж, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлж, тус журмын төслийг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024 оны 3 дугаар улирлаар байдлаар нийт 60 ББСБ, 3 арилжааны банк факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн салбарын хэмжээнд 18 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлагын үлдэгдэлтэй байна.
		Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024	1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу СЗХ-ны 2023 оны 189 дүгээр тогтоолоор “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам”-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 6251 дугаарт бүртгүүлсэн. Ийнхүү үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. 2/ Сангийн сайд, СЗХ-ны даргын 2023 оны А-286/528 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д үүсмэл санхүүгийн хэрэгслийн ангилал, бүртгэлийг тодорхойлон нэмж тусгасан. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 1 ББСБ 0.8 тэрбум төгрөгийн своп хэлцэл хийсэн.
	1.5.5.Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх			
1.7.Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй,	1.7.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2021	УИХ-ын 2021.05.21-ний өдрийн хуралдаанаар Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг эцэслэн баталсан.

		хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах	хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх			
2	Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах	2.2.Банкны засаглал, хяналтыг сайжруулах	2.2.3.Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, ашигт ажиллагааны зорилт, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тухайн санхүүгийн жил, үйл ажиллагаа, ашигт ажиллагаагаар бус урт хугацааны үзүүлэлт, үр дүнгээр тогтоодог байх агуулгаар холбогдох журам гаргаж, хэрэгжүүлэх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024	СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” батлсан. Тус журамд эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх, компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тодорхойлох зохицуулалтыг тусгаж, залгамж халааны бодлогын, цалин, урамшууллын бодлогын бичиг баримтын загварыг оруулсан.

			Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021	1/ СЗХ болон МБ-ны хамтарсан ажлын хэсэг нь Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг 2019.12.12-ны өдөр УИХ-ын гишүүн С.Батболд болон УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир нар УИХ-д өргөн мэдүүлсэн ч УИХ-аас 2020.10.08-ны өдөр 28 дугаар тогтоолоор хууль санаачлагчид буцаасан. Иймд хуулийн төслийг шинээр боловсруулж Азийн хөгжлийн банкны "Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн зохицуулалтыг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд олон улсын зөвлөхүүд, олон нийт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлэг хийж, санал авч нэгтгэн хууль санаачлагчид хүргүүлээд байна. Хуулийн төсөл батлагдсанаар зээлийн хүү буурах, мөнгө хүүлэлттэй тэмцэх, санхүүгийн үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах институт бий болж санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нөхцөл бүрдэнэ. 2/ Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр СЗХ-ноос "Санхүүгийн зохицуулах хорооны өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын төслийг боловсруулаад байна. 3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй буюу нээлттэй хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж буй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хамгаалах зохицуулалтыг тусгасан. 4/ СЗХ-ны 2021 оны 25 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-д Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь үйлчлүүлэгчид даатгалын гэрээг байгуулахаас өмнө ба дараа
2.4.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх	2.4.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох				

бүтээгдэхүүн, үйлчилгээ, гэрээний нөхцөлтэй холбоотой зөалт, шаардлагуудыг заавал танилцуулж баримтжуулан ажиллах шаардлагыг тусгаж даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын орчныг сайжруулсан.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэд олон нийтээс СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээлэлд боловсруулалт, судалгаа шинжилгээ хийж, даатгалын маргааныг урьдчилан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгасан. Тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан ба УИХ-ын 2024 оны намрын эээлжит чуулганаар хэлэлцүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна.

5/ Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо" сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөгийг орон нутгуудад бүсчлэн амжилттай зохион байгуулсан. Үүнд: Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор зэрэг нийт найман аймаг. Түүнчлэн, СЗХ-ны үйл ажиллагаанд хамаарах үйл явдлын нийт 195 мэдээ, ээлжит хуралдааны 21 мэдээ, нийт 43 видео нэвтрүүлэг, ярилцлага, нийтлэлийг олон нийтийн мэдээллийн холбоос www.sankhuugiinbolovsrol.mn, "Ikon.mn", "Eagle.mn", "Itoim.mn" "Zarig.mn" болон СЗХ-ны цахим хуудас зэрэгт байршуулж, СЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн мэдээ мэдээлэл олгох QR бүхий анонс, стенд, тараах материалыг нийт 3500 гаруй иргэдэд хүргэж ажиллалаа."

6/ Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийг даатгах харилцааг зохицуулсан бүлэг шинээр тусгасан. Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг баримт

бичгүүдийн төслийг эцэслэн хууль санаачлагч УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, УИХ-ын ЭЗБХ-ны дарга Ц.Цэрэнпунцаг нарт СЗХ-ны 2023.12.26-ны өдрийн 1/4922, 1/4923 тоот бичгүүдээр тус тус хүргүүлсэн.

	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо	2020-2021	1/ ББСБ-ын зээлийн бүтээгдэхүүн, хугацаа, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийн загвар маягтыг Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоонд СЗХ-ны 2021.03.25-ны өдрийн 7/1115 тоот албан бичгээр хүргүүлсэн ба тус загвар маягтын дагуу бэлтгэн www.bbsb.mn сайтад тавьж олон нийтэд тогтмол мэдээлж байна.
2.4.2. Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх			СЗХ, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой шинэчлэн байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн 3.2.2-т "Холбооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, гишүүдэд чиглэсэн үнэ төлбөргүй бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, сайжруулах", 3.2.6-д "ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн мэдээллийг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Банк бус санхүүгийн хууль эрх зүйн орчин, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, татварын бүртгэл, тайлагналын сургалтыг 123 ББСБ-д зохион байгуулсан. 2/ Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах" төслийн хүрээнд 2023 онд баруун бүсийн 5 аймгийн банк бус санхүүгийн байгууллагын 34 гүйцэтгэх удирдлага, зүүн бүсийн банк бус санхүүгийн байгууллагын 30 гүйцэтгэх удирдлагад хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийн талаарх танилцуулга сургалт зохион байгуулсан. 3/ Сангийн сайдын 2024.03.28-ны өдрийн А/49 дугаар тушаалаар "Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчилсэн батлсан. Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламж болон зээлийн жигнэсэн дундаж хүүгийн мэдээллийг улирал бүр ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр олон нийтэд мэдээлж, СЗХ-ны цахим хуудаст байршуулж байна.
2.4.3.Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын	Санхүүгийн зохицуулах	2020-2024	1/ УИХ-ын 2021.01.29-ний өдрийн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг

зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	хороо, Засгийн газар		бууруулах тухай хуульд барьцаалан зээлдүүлэх газар болон зээлдэгч хоорондын зээлийн гэрээний харилцаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. 2/ Мөнгөн зээлийн үйл ажиллагаат зохицуулах тухай хуулийн төсөлд СЗХ-ноос 2020.04.13, 2020.10.06, 2021.01.13-ны өдрүүдэд тус тус албан бичгээр 3 удаа санал хүргүүлж, ЭЗБХ болон төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэгт оролцсон. УИХ-ын 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт баталсан. Тус хуулиар СЗХ-нд олгогдсон бүрэн эрхийн хүрээнд СЗХ-ны 2023 оны 81 дүгээр тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам", 82 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам", 83 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам", 84 дүгээр тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам", 85 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. СЗХ-оос Нийслэлийн 9 дүүрэгт 375 барьцаалан зээлдүүлэх журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн гүйцэтгэх, удирдлага менежерүүдэд 2023.09.07-12-ны өдрүүдэд "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мэдлэг олгох" сургалтыг зохион байгуулсан. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 274 хуулийн этгээд, 127 иргэн нийт 401 этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Хуулийн этгээдийн 70 нь СЗХ-нд, 204 нь аймаг, нийслэлийн засаг даргад бүртгүүлжээ.
2.4.4.Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн	Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2024	1/ Коронавирус халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх

	хүүгийн хязгаарыг тогтоох /Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын х үү/			журмын тухай хуулиар барьцаалан зээлдүүлэх газрын зээлийн хүүд тодорхой хугацаагаар хязгаарлалт тогтоосон. 2/ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасны дагуу Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар, 02 дугаар тогтоолоор "Зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар"-ыг, 03 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүг бодох, тооцох аргачлал"-ыг тус тус баталсан бөгөөд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024.02.06-ны өдрийн 6594, 6595, 6596 дугаарт тус тус бүртгэсэн. 3/ Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21.3-т заасны дагуу МБ-ны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2023 оны А106/298 дугаар хамтарсан тушаалаар "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал"-ыг баталсан. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын зээлийн хүү, шимтгэл хураамж, ББСБ-уудын эх үүсвэрийн өртөг, зардал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг 2022, 2023 болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар судалж, холбогдох санал дүгнэлт боловсруулсан.
2.5.Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх	2.5.1.Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээллийн агуулгыг өргөжүүлж, олон улсын жишигт	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021	МБ-наас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчийн операторын эрхийг "Титан си ар" ХХК, "Бүрэн скор" ХХК-д тус тус олгосонтой холбогдуулан аль нэгтэй нь хамтран ажиллах гэрээг 2024 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 492 ББСБ-ын 91.1 хувь буюу 492, 183 ХЗХ-ны 59.0 хувь буюу 109 ХЗХ шинэчлэн байгуулж, холбогдох мэдээллээ нийлүүлж байна.

		нөхцөлийг бүрдүүлэх	нийцсэн программ хангамжийг ашиглах			
3	Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах	3.1.Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх	3.1.1.Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар,	2020-2024	1/ Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй 28 үнэт цаасны компани өөрийн цахим сайт, аппликейшнээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж, цахимаар үнэт цаасны данс нээх боломжийг бүрдүүлсэн. 2/ ББСБ-ын финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгэхэд дүгнэлт гаргах Цахим зөвлөлийн бүрэлдэхүүнийг СЗХ-ны даргын 2022 оны 433 дугаар тушаалаар батлсан. Цахим зөвлөл байгуулагдсанаар харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх боломж бүрдсэн. 3/ СЗХ-ны 2020 оны 495 дугаар тогтоолоор батлсан “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-д цахим систем ашиглаж гадаад валютын арилжаа эрхлэх тохиолдолд ISO/IEC 27001 стандартыг хангаж ажиллах эрх зүйн зохицуулалтыг тусган СЗХ-ны 2023.06.23-ны өдрийн 220 дугаар тогтоолоор батлсан. Мөн СЗХ-ны 2022 оны 160 дугаар тогтоолоор батлсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д ISO 27001 стандартын шаардлага хангах зохицуулалтыг тусгасан. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 62 ББСБ-уудын 59 аппликейшн СЗХ-ны дэргэдэх Цахим зөвлөлөөс холбогдох зөвшөөрөл авч, ISO стандартын шаардлагыг нэвтрүүлэн зах зээлд үйлчилгээ үзүүлж байна. 4/ Зээлдэгчийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор СЗХ-ны 2022 оны 527 дугаар тогтоолоор финтек зээлийн бүтээгдэхүүний өр/орлогын харьцааг 70 хувиас ихгүй байхаар тогтоосон. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 62 ББСБ технологид суурилсан зээлийн үйлчилгээ эрхэлж 1.6 сая зээлдэгчид 1.2 их наяд төгрөгийн зээл олгосон.

5/ АХБ-ны дэмжлэгтэйгээр СЗХ-ны хэрэгжүүлж буй “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр”-ийн хүрээнд финтекийн салбарыг хөгжүүлэх замын зураг, болон суптекийг нэвтрүүлэх зөвлөмжийн төслийг боловсруулж СЗХ-нд ирүүлээд байна.

6/ API системийг дотооддоо хөгжүүлэн vaspapi.frc.mn-р дамжуулан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан мэдээг өдөр бүр тогтмол авдаг болсон. Ингэснээр тухайн салбарын нийт арилжаа, үнэлгээ болон хэрэглэгчдийн тоог бодит цагийн горимоор хянах боломж бүрдсэн.

Технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндбокс зохицуулалтын орчныг бий болгох харилцааг зохицуулсан журмыг МБ-ны Ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны А-63/64/32/А/27 тушаалаар батлаж 2023 оны 190/71/А-72 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 23 компани өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс орчинд турших хүсэлт ирүүлснээс 8 компани сэндбокс орчинд орсон.

7/ Даатгалын салбарын улирлын нэгдсэн тайланд цахим даатгалын талаарх тоо мэдээллийг тайлагнах зорилгоор Даатгалын багц дүрмийн 11 дүгээр хавсралтад СЗХ-ны 2023 оны 741 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д даатгалын үйл ажиллагаанд цахим болон аливаа дэвшилтэт техник, технологийг ашиглах зохицуулалтын талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг тус тус

			боловсруулж, олон нийтээс санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулж, даатгалын салбарын оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Улмаар төслийг эцэслэн СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. 8/ Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд даатгалын үйл ажиллагааг цахим технологи ашиглан зохион байгуулах, даатгалын гэрээний болон бусад харилцаанд биометрик мэдээлэл ашиглах суурь зохицуулалтуудыг тусгаж УИХ-ын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар цахим даатгалын үйлчилгээ нийт даатгалын үнэлгээний 0.31 хувийг, даатгалын нийт хураамжийн орлогын 0.29 хувийг, нийт даатгалын нөхөн төлбөрийн 0.18 хувийг, нийт байгуулсан даатгалын гэрээний 0.71 хувийг тус тус эзэлж байна.
3.1.2.Зээлийн, барьцааны, даатгалын зэрэг гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2024	1/ Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг, Иргэний хуулийн 42[1] дүгээр зүйлд цахим хэлбэрээр хийх хэлцлийн зохицуулалтыг тусгасан. 2/ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд банк бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэх тохиолдолд зээлийн гэрээг тоон гарын үсгээр баталгаажуулах, харилцагчийг зайнаас таньж мэдэх зорилгоор дэвшилтэт технологи ашиглах зохицуулалт тусгасан. 3/ Даатгалын багц хуулийн төсөл болон Монгол Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд даатгалын гэрээг цахимаар хийх боломж олгох зохицуулалтуудыг тусгасан. 4/ Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хадгаламж, зээлийн

	тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх			гэрээг цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн цахим хэлбэрээр байгуулах боломж олгох зохицуулалтыг тусгасан.
		Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2021	1/ Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд СЗХ даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаар тогтоох зохицуулалт тусгасан. 2023.06.06-ны өдөр "Даатгалын салбарыг татварын бодлогоор дэмжих нь" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд даатгалын салбарт тулгамдаж буй татварын хууль, эрх зүйн орчны талаар судалж, дараах саналыг боловсруулан УИХ-ын дэргэдэх Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо (ЭЗБХ) болон Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. • даатгуулагч аж ахуйн нэгж байгууллагын хохирлыг нөхөн төлөхөөр шилжүүлж буй даатгалын нөхөн төлбөрөөс татвар авч байгаагаас даатгуулагч тэр хэмжээгээр хохирлоо буцаан сэргээх боломжгүй болж, хохирч байгаа тул уг заалтыг хасах; • олон улсын давхар даатгагчид шилжүүлж буй давхар даатгалын хураамжид татвар суутган тооцохгүй байх зэрэг даатгагч болон даатгуулагчийн хувьд эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэн аливаа эрсдэлийг даатгалын тусламжтайгаар бууруулах; • томоохон хэмжээний хохирлоо даатгалын тогтолцоонд шилжүүлэхэд хязгаар тавьсан зохицуулалтуудыг хасах. 2/ 2023 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлт оруулж 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн. Үүнд: • Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбоотой зардлыг 20 хувиар
3.2.Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах	3.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Өрсөлдөөний тухай, Татварын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх			

						нэмэгдүүлж тооцон албан татвар ногдох орлогоос хасаж тооцох; • Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагдах ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй компанийн хувьцааны ногдол ашгийн суутган татварыг 10 хувь байсныг 5 хувь болгон бууруулах; • Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх; • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2020 онд 50 хувиар; • Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар;. • Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьцаа, үнэт цаас борлуулсан орлогод татвар ногдуулахдаа тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцох.
4	Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг	4.1.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл,	4.1.1.Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг	Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2021	Үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжихтэй холбогдуулан бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:

бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах	хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих	боловсруулж, өргөн мэдүүлэх

- 2020 онд "ҮЦТХТ" ХХК нь анхдагч зах зээл дэх арилжааны шимтгэл 0.24 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.12 хувь болгосон;
- 2020 онд "МҮЦКТ" ХХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийг хэлцэл тус бүрээс 0.12 хувь болгон 50 хувиар бууруулсан;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь байсныг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоож, 50-75 хувиар бууруулан 0.25-0.5 хувь болгосон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.05 хувь болгосон;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Бүртгэлийн журам"-д хувьцааг бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 20-40 хувиар бууруулан 0.06-0.08 хувь болгосон. Мөн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 0-36 хувиар бууруулан 0.064-0.1 хувь болгосон;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Арилжааны журам"-д хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаанд худалдсан тал шимтгэлгүй байх, түүнчлэн худалдан авсан талын хувьд хэлцлүүдийн үнийн нийлбэр дүнгээс хамааруулан шимтгэлийг тооцдог байх зохицуулалтыг тусгаж СЗХ-ны даргын 2022 оны 335 дугаар тушаалаар батламжлуулсан;

- Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчид /брокер/-аас СЗХ-нд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан угаасан болон самнасан ноолуурын худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн "0.04" хувиас доошгүй байсныг СЗХ-ны 2023 оны 399 дүгээр тогтоолоор 2024.07.01-ний өдрийг хүртэл хугацаанд угаасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг "0.02" хувь, самнасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг "0" хувиар тус тус тогтоосон;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2023 оны 483 дугаар тушаалаар батламжилсан. Тус журмын нэмэлт өөрчлөлтөөр хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.25 хувь, жилийн үйлчилгээний хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.025 хувь болгон тус тус бууруулан тогтоосон;
- "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийн "Үнэт цаасны клирингийн журам"-ыг СЗХ-ны даргын 2023 оны 545 дугаар тушаалаар батламжилсан. Тус журмын шинэчилсэн найруулгаар засгийн газар, аймаг, нийслэлийн өрийн хэрэгсэл гаргахад тооцогдох клирингийн үйлчилгээний шимтгэлийг бусад өрийн хэрэгсэл гаргагчийн шимтгэлээс 2 дахин багаар тогтоосон;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 46 дугаар тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2023 оны

				558 тоот тушаалаар батламжилсан. Түс журмын нэмэлт, өөрчлөлтөөр "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар хийгдэх хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн шимтгэлийг арилжааны үнийн дүнгээс үл хамааран 0.3 хувиар тооцох, арилжааны шимтгэлийн хувь хэмжээг 25 хувиар бууруулан тогтоосон. • Засгийн газрын гаргасан өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаанаас худалдагч талаас авдаг байсан 0.00175 хувийн шимтгэлийг авахгүй болж байгаагаас гадна, Засгийн газрын өрийн хэрэгсэлд ногдох хадгаламжийн үйлчилгээний хөлс бондын нэрлэсэн үнээс хамааруч нэгж бондоос 2-50 хүртэл төгрөгийн хөлс авдаг байсан нь 20 хувиар буурч үнийн дүнгийн 0.016 хувь байхаар тогтоосон. • Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн спот болон форвард гэрээний арилжаанаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийн дээд хязгаарыг худалдан авагч талаас 0.5 хувиас ихгүй, худалдагч талаас 1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй байхаар СЗХ-ны 2023 оны 793 дугаар тогтоолоор тогтоож, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6593 дугаарт бүртгэсэн.
4.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх	4.2.1.Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотой дүрэм, журам гаргаж, биржийн болон биржийн бус зах	Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024	1/ "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ыг СЗХ-ны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан. Уг журмаар "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" /МҮЦАЭХ/ биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Иймд МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 8 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн ерөнхий журам", "Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам", "Биржийн бус зах зээлийн арилжааны багц журам"-ыг баталсан. Биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчин бий болсноос хойш өрийн

зээлээр дамжуулан
арилжаалах
нөхцөлийг
бүрдүүлэх

хэрэгслийн анхны арилжааг 2021 оны 9 дүгээр сард амжилттай эхлүүлсэн

Инновацын тухай хуулийн 12[1] дэх заалтын дагуу гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргахтай холбогдсон харилцааг "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-д тусгаж, нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор батлсан.

Мөн биржийн бус зах зээл дээрээс дотоодын аж ахуйн нэгжийн санхүүжилт татах сонирхлыг улам нэмэгдүүлж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулж, түүнтэй холбоотой гарах зардал, өртөг, хугацаа багасгах зорилгоор "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгыг СЗХ-ны даргын 2023 оны 17 дугаар тушаалаар батламжилсан.

2/ "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д компанийн бонд гаргахад СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагад хийгддэг хяналтын ажиллагааны давхардлыг арилгах, бүртгэлийн үйл ажиллагааны хугацааг багасгах, нэг удаа СЗХ-нд бүртгүүлсэн өрийн хэрэгслийг хэсэгчлэн, үе шаттайгаар нийтэд санал болгох зэрэг зохицуулалтыг тусгасан.

2021 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д аймаг, нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусган СЗХ-ны 2022 оны 68 дугаар тогтоолоор батлсан.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар биржийн бус зах зээлд нийт 67 үнэт цаас гаргагчийн 924.5 тэрбум төгрөгийн болон 23.8 сая ам.долларын үнийн дүн бүхий 84 өрийн хэрэгсэл бүртгэгдсэн. Үүнээс бодитоор 934.7 тэрбум төгрөгийгболон , 20.9 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн.

			Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	2020-2024	1/ СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020 оны 329/187 дугаар хамтарсан тушаалаар Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуульд дараах зарчмын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгаа, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд дараах саналыг боловсруулж Сангийн яаманд СЗХ-ны 2021.03.16-ны өдрийн 1/964 тоот, УИХ-ын ЭЗБХ-нд 2021.03.31-ний өдрийн 1/1222 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Үүнд: • Тусгай сангуудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалттайгаар Засгийн газрын баталгаатай, Хөгжлийн банкны гаргасан болон тус байгууллагын баталгаатай дотоодын зах зээлд гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх; • Тусгай чиглэл, үүрэгтэй сангуудаас олгох санхүүжилтийг зөвхөн банкны зээлээр дамжуулан санхүүжүүлэхгүй, хөрөнгийн зах зээл дээр тухайн чиглэлийн хуулийн этгээдийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах хэлбэрээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх; • Ирээдүйн өв сан гэх мэт хуримтлалын сангуудыг дотоодын зах зээлд Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан, эсхүл тус байгууллагын баталгаатайгаар гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх. 2/ Даатгалын компаниудын үндсэн үйл ажиллагааны нэг болох хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлж олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулах, эрсдэлийг тархаах зорилгоор холбогдох журмуудад
4.3.Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох	4.3.1.Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах агуулгаар сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх			

				өөрчлөлт оруулж СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор батлсан. 3/ Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль заасан тодорхой санхүүгийн хэрэгслүүлэд хөрөнгө оруулах холбогдох зохицуулалтыг тусгах саналыг 2024.04.01-ний өдөр хүргүүлсэн.
			Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024	1/ СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020.09.30-ны өдрийн 329/187 дугаар хамтарсан тушаалаар хөрөнгийн бирж болон биржийн бус зах зээл дээр арилжааны банкны эзэмшиж буй үнэт цаасыг нэмж оруулах талаар судлах дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг гаргасан: • Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон үнэт цаасны жагсаалтад хөрөнгийн бирж болон биржийн бус зах зээл дээр арилжаалсан, арилжааны банкны эзэмшиж буй үнэт цаасыг нэмж оруулах; • Хөрөнгө оруулалтын банк байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх. Санал дүгнэлтийг Сангийн яаманд СЗХ-ны 2021.03.16-ны өдрийн 1/964 тоот, УИХ-ын ЭЗБХ-нд 2021.03.31-ний өдрийн 1/1222 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2/ СЗХ-ноос банкнууд хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчаар оролцох боломжийг хязгаарласан Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг “Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах дотоодын үнэт цаасны зах зээлд гаргасан компанийн өрийн хэрэгслээс бусад үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компани, түүний нэгдлийн оролцогчийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй.” гэж өөрчлөн найруулах саналыг МБ-ны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд
4.4. Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх	4.4.1.Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, улам жлах				

2021.03.12-ны өдрийн 1/853 тоот, УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнд 2021.03.12-ны өдрийн 1/854 тоот, УИХ-ын гишүүн С.Чинзоригт 2021.03.12-ны өдрийн 1/855 тоот СЗХ-ны албан бичгээр тус тус хүргүүлсэн.

3/ 2021 онд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор арилжааны банк хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргаж нээлттэй хувьцаат компани болох суурь нөхцөл бүрдсэн. Иймхүү банкны салбарын реформын хүрээнд дээрх системийн банкнууд хөрөнгийн зах зээл дээр IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох ажиллагааг хэрэгжүүлэн "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам"-ыг МБ-ны ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2021 оны А-90/85 дугаар хамтарсан тушаалаар, "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ыг МБ-ны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2021 оны А-262/262 дугаар хамтарсан тушаалаар тус тус баталсан.

Үүний үр дүнд "Богд банк" ХК болон системд нөлөө бүхий 5 банк болох "Төрийн банк" ХК, "Голомт банк" ХК, "ХААН банк" ХК, "Худалдаа Хөгжлийн банк" ХК, "Хас банк" ХК-ийн IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжсэн. Нийт давтагдсан тоогоор 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478.54 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна зах зээлийн үнэлгээг 5.86 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн.

4/ 2023 онд УИХ-аас Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль баталсантай холбогдуулан "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам", "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам", "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам" болон "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлага"-ыг боловсруулж МБ-ны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2023 оны А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалаар тус тус батлсан.

----- oOo -----